



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хутаг-Өндөр сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: БУА-2025/004/НА-СА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган аймаг 2025 он	Дарга, тэргүүлэх аудиторын албан тушаалын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: А.Сувдаа Утас: 70342495 Цахим хаяг: suvdaaa@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс: 7034-2580
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2025.03.24 № 369
танай _____ ны № _____ т

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ
ДАРГА О.ДАЛАЙЦЭРЭН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хутаг-Өндөр сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Хутаг-Өндөр сумын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах үндэслэлээр хязгаарлалттай дүгнэлт өгч байна. Үүнд:

- БХС-аас эргэлтийн хөрөнгө бэлтгэсэн ч шууд зардаар бүртгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөжийг бүрэн биелүүлээгүй,
- ЖДҮДС-аас олгосон зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн ч дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй,
- БХС-д нөхөн сэргээлтийн орлого төвлөрсөн ч холбогдох тооцоолол, гүйцэтгэл, тайлан байхгүй,
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний 2 төсвийн шууд захирагч, 2 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 4 тусгай сангаас төсвийн шууд захирагч 1, орон нутгийн өмчит 1 аж ахуйн нэгж дүгнэлтэд хамрагдсанаас хязгаарлалттай дүгнэлт авсан зэрэг нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.6, УСНББОУС 1, 12-той нийцэхгүй, иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

632502731

Асуудлыг онцолсон хэсэг

“Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дүгээр тогтоолын дагуу тус байгууллагын албан хаагчдын үндсэн цалинг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс шинэчлэн баталсан мөн Засгийн газрын 2024 оны 82 дугаар тогтоолын нэмэлт өөрчлөлтийн дагуу аймгийн ИТХ-ын 2024 оны XXV/05 дугаар тогтоол, сумын ИТХ-ын 04 дүгээр тогтоолоор орон нутгийн нэмэгдлийг олгосон байна. Үүнтэй холбоотойгоор цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардал өмнөх оноос 51.6 хувиар өссөн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 7 хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 3,741.1 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 3,228.2 сая төгрөгийг зарцуулж 512.9 сая төгрөгийг дутуу зарцуулжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН ТУШААЛЫН
АЛБАН ҮҮРГТИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

ЖЭНХЦООДОЛ

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөг/

Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	822.0	1,141.3
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,815.3	7,686.3
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	7,637.3	8,827.6
Нийт өр төлбөрийн дүн	47.7	110.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,589.6	8,717.2
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,637.3	8,827.6
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	6,232.9	8,322.0
Үйл ажиллагааны зардлын дүн	5,404.5	7,217.0
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	828.4	1,105.0
Үйл ажиллагааны бус үр дүн	(590.6)	(0.1)
Үйл ажиллагааны нийт үр дүн	237.8	1,105.1
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан/		
Дархин илэрхийлсэн үлдэгдэл	7,351.7	7,612.3
Тайлант оны үр дүн	237.8	1,104.9
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	7,589.5	8,717.2
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	6,069.1	7,471.3
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	5,204.3	6,165.0
Үйл ажиллагааны мөнгөн ЦМГ	864.8	1,306.3
Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	700.0	931.0
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(700.0)	(931.0)
Санхүүгийн үйл ажиллагааны ЦМГ	(92.1)	(0.3)
Нийт ЦМГ	72.7	375.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	258.6	331.4
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	331.3	706.4
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		3,228.2
Урсгал зардал		2,438.9
Хөрөнгийн зардал		789.0
Эргэж төлөгдөх төлбөрийн хассан цэвэр зээл		0.3
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		3,228.2
Улсын төсвөөс санхүүжих		
Орон нутгийн төсвөөс санхүүжих		3,259.9
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас		108.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		210.8
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		351.3

Гурав. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага нь Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн ИТХ-аас баталсан дэд хөтөлбөрүүд, Төр засгийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэх, Төрийн үйлчилгээг иргэдэд хөнгөн шуурхай хүргэх, олон улсын байгууллагаас хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хөрөнгө, ОНХС-гийн хөрөнгийг зөв зохистой ашиглан хэрэгжүүлэх, иргэдийн оролцоо ил тод байдлыг хангах, иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх, хүн амаа өсгөх, сум орон нутгаа хөгжүүлэх, зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажиллажээ.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ОНХС-аас нийт 37 төсөл арга хэмжээг баталснаас ТЭЗҮ болон төсвийн тооцоололгүй 145.7

сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээг баталсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.5-д заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүйд албан шаардлага өгч ажиллалаа.

Аж ахуйн комисст ажиллаж байгаа ажлын хэсгийн гишүүдийн хувцас 810.0 төгрөг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүйд төлбөрийн акт тогтоолоо

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1.Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд Сумын ИТХ-ын тогтоолоор баталсан төсөв 3,545.2 сая төгрөг, Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, сумын хүрэх үр дүнг баталсан ч төлөвлөгөө, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг шилэн дансны нэгтгэсэн системд мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.5, 6.3.1, 6.3.8, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтын 3.1.1, 3.1.8, 3.1.11-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

2.Санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг байршуулаагүй “Илчит Хутаг” ОНӨХХК 239.0 сая төгрөг, мэдээллийг хугацаанд нь мэдээлээгүй ЗДТГ, ИТХ нийт 1,359.2 сая төгрөгийн 3 албан шаардлага өгч ажиллалаа.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар өглөг, авлагыг тайлан бүртгэлд тусгаагүй ч тайлант хугацаанд барагдуулсан болон санхүүжилт олгоогүй байх эсэхийг хянаж үзэх.

Зургаа. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 5.9 сая төгрөгийн 2 алдаа илэрснийг залруулж, 91.4 сая төгрөгийн 5 зөрчил¹ илэрснээс, 71.5 сая төгрөгийн 2 албан шаардлага, 19.9 сая төгрөгийн 3 зөвлөмж өгч ажиллаа.

Төсвийн шууд захирагчийн хүрээнд аудитаар нийт 1,112.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 985.2 сая төгрөгийн 17 алдааг залруулж, 2.5 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 88.2 сая төгрөгийн 12 албан шаардлага хүргүүлж, 37.0 сая төгрөгийн 10 зөвлөмж өгсөн байна.

6.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

6.2 Албан шаардлага

1. Хутаг-Өндөр сумын байгаль хамгаалах санд нөхөн сэргээлтээс нийт 19.4 сая төгрөгийн орлого төвлөрсөн ч холбогдох гүйцэтгэлийн тайлан, баримт байхгүй

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 14 дүгээр зүйлийн 14.3.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 16.5.6 дахь заалттай нийцэхгүй, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-т “хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

2. Байгаль хамгаалах сангаас нийт 52.1 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгө бэлтгэсэн ч шууд зардлаар бүртгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2”, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2 дахь заалттай нийцэхгүй, ангилал, иж бүрэн байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.10-т “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтыг үндэслэн албан шаардлага өгөх

6.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: ЖДҮДС-аас олгосон 19.4 сая төгрөгийн зээлийн эргэн төлөх хугацаа хэтэрсэн ч дараагийн шатны арга хэмжээ авч ажиллаагүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.3, Сумын ИТХ-ын 2021 оны 36 дугаар тогтоолын хавсралтын 2, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангаас олгосон зээлийг эргэн төлүүлэх, барагдуулах, хууль хяналтын байгууллагад шилжүүлэх ажлын зохион байгуулах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын түүхт 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББ-ийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.5, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ойн арга хэмжээний хүрээнд бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгах ажлыг зохион байгуулах.

3. Татварын орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Байгаль хамгаалах сангийн орлогыг бүрдүүлэхдээ гүйцэтгэлээрх татварын орлогын дүнгээс орох хувиас 0.4 сая мянган төгрөгөөр илүү санхүүжүүлсэн /Тогтоолоор баталсан хувиас илүү/ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2, 16.5.6, ЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолын хавсралт журмын 2.5, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Батлагдсан хувь хэмжээгээр санхүүгийн эх үүсвэр олгох, шаардлагатай тохиолдолд тодотголоор орлогын доод хувийг нэмэгдүүлж батлуулах.

Долоо. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая.төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаа- гүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ	4	901.1	3	892.60	1	8.5	4	901.1		0	0	0
ИТХ	5	18.1	3	2.10	2	16.0	5	18.1				
ХХС	1	3.9			1	3.9	1	3.9				
СДОА	2	40.0			2	40.0	2	40.0				
"Илчит Хутаг" ОНӨХХК	5	22.0	4	21.20	1	0.8	5	22.1				
ТТЗ	2	5.9			2	5.9	2	5.9				
Дүн	19	991.0	10	915.9	9	75.1	19	991.1	0	-	0	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн										
ЗДТГ	11	65.0	1	0.8	6	28.7	3	35.5	1	1	0	0
ИТХ	2	1.7	1	1.7			1	-				
ХХС	1	-					1	-				
СДОА	4	2.4			2	2.4	2	-				
"Илчит Хутаг" ОНӨХХК	5	58.6			4	57.1	1	1.5				
ТТЗ	5	91.4			2	71.5	3	19.9				
Дүн	28	219.1	2	2.5	14	159.7	11	56.9	1	1	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая.төгрөг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
ЗДТГ	1	1,183.1			1	1,183.1		
ИТХ	1	176.1			1	176.1		
"Илчит Хутаг" ОНӨХХК	1	239.0			1	239.0		
ТТЗ	1	3,545.2			1	3,545.2		
Дүн	4	5143.4	0	0	4	5143.4	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ЗДТГ	1	0					1	0
"Илчит Хутаг" ОНӨХХК	1	0					1	0
ОНХС	1	145.7			1	145.7		
Дүн	3	145.7	0	0	1	145.7	2	0
Нийт дүн	7	5,289.1	0	0	5	5,289.1	2	0

Найм. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр						
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй	Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
A	1	2	3	4	5	7	8	9	10

1	ТШЗ	6	2	4		0	2	0	0
2	Төсөл, хөтөлбөр	0							
3	ЗГТС	0							
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ	0							
	НИЙТ	7	3	4	0	0	3	0	0

-oOo-